

СУРГАЛТЫН ТӨЛБӨР ХАРИУЦАХ ГЭРЭЭ

2021 оны 03 сарын 29 өдөр

№21/434

Улаанбаатар хот

Нэг талаас "ДЦС-2" ТӨХК-ийг төлөөлж Захиргаа удирдлагын хэлтсийн дарга албан тушаалтай Г.Мөнгөнцэцэг /цаашид "Компани" гэх/, нөгөө талаас "ДЦС-2" ТӨХК-д Турбин-хими цехийн ээлжийн дарга албан тушаалтай Цэндийн Энхсайхан /цаашид "ажилтан", хамтад нь "талууд" гэх/ нар Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Компанийн 2021 оны сургалтын төлөвлөгөөг тус тус үндэслэн талууд дараах нөхцөлийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү гэрээгээр ажилтанд мэргэжил эзэмшүүлэх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, хөгжүүлэх зорилгоор дотоодын мэргэжлийн их, дээд сургуульд хамруулан сургахдаа сургалтын төлбөрийг бүрэн төлөх, ажилтан амжилттай суралцаж төгссөний дараа компанид 5-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажиллахтай холбогдон талуудын хооронд үүсэх эрх зүйн харилцааг зохицуулна.
- 1.2 Гэрээний дагуу Компани ажилтныг Монгол улсын Шинжлэх ухаан технологийн их сургуулийн "Эрчим хүчний сургууль"-ийн Дулааны инженерийн /оройн ангид/ чиглэлээр, 3.5 жилийн хугацаанд суралцахад нь дэмжлэг үзүүлэн сургалтын төлбөрийг 100 хувь буюу ойролцоогоор 11 сая /Арван нэг/ төгрөгийг хариуцан төлнө.

Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1 Энэхүү гэрээг 2019 оны 10 сарын 01-ний өдрөөс эхлэн 2022 оны 07 сарын 01-ний өдөр хүртэл 3.5 /6 хичээлийн улирал/ жилийн хугацаатай байгуулав.
- 2.2 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд Ажилтан сургуулийг амжилттай суралцаж төгссөний дараа энэхүү гэрээнд заасан тогтоосон хугацаанд ажилласнаар дуусгавар болно.

Гурав. Гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл

- 3.1 Компаниас төлөх сургалтын төлбөрийн хэмжээг тухайн сургуулиас нийтэд зарласан хэмжээгээр буюу уг сургуулиас Ажилтанд олгосон төлбөрийн нэхэмжлэхийг үндэслэн тогтооно.
- 3.2 Компани нь сургалтын төлбөрийг сургуулиас тогтоосон хугацаанд зөвхөн тус сургуулийн дансанд тушаана.
- 3.3 Ажилтан нь энэхүү гэрээний 5.2.2-д заасан үүргийг биелүүлснээр Компани сургалтын төлбөрийг үргэлжлүүлэн төлөх ба биелүүлээгүй тохиолдолд Компани төлбөр төлөх үүргээ биелүүлэхээс татгалзаж болно.

Дөрөв. Компанийн эрх, үүрэг

4.1 Компани дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- 4.1.1 Ажилтанд тухайн сургуулийн захиргаанаас сургуульд элссэнтэй холбогдуулан олгосон бичиг баримтын хувийг төлбөрийн нэхэмжлэхийн хамт Ажилтнаас шаардах;

- 4.1.2 Хичээлийн жилийн улирал бүрийн эцэст Ажилтнаас дүнгийн хуулбарыг шаардах;
- 4.1.3 Ажилтан гэрээнд заасан хугацаанд сургуулиа төгссөнөөр Компанид энэхүү гэрээгээр тохиролцсон тогтоосон хугацаанд ажиллахыг шаардах;
- 4.1.4 Дараах тохиолдолд энэхүү гэрээг дангаар цуцлан, өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй. Үүнд:
 - 4.1.4.1 Ажилтан нь 2 улирал дараалан 3.0-аас доош голч дүнтэй суралцсан;
 - 4.1.4.2 Ажилтны буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан сургуулиас хөөгдсөн;
 - 4.1.4.3 Сахилга хариуцлагын ноцтой зөрчил гаргасан;

4.2 Компани дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- 4.2.1 Гэрээний 1.2-д заасан төлбөрийг тогтоосон хугацаанд тухайн сургуулийн дансанд шилжүүлэх;
- 4.2.2 Ажилтныг суралцах нөхцөл боломжоор хангах;

Тав. Ажилтны эрх, үүрэг

5.1 Ажилтан дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- 5.1.1 Компаниас гэрээний 4.2.1-д заасан төлбөр төлөх үүргээ биелүүлэхийг шаардах;
- 5.1.2 Суралцаж төгссөний дараа Компанид үргэлжүүлэн ажиллах;

5.2 Ажилтан дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- 5.2.1 Сургуулийн захиргаанаас олгосон бичиг баримтын хуулбарыг Компанид гаргаж өгөх;
- 5.2.2 Сургуулиас баталсан сургалтын төлөвлөгөөнд заасан мэдлэг чадварыг бүрэн эзэмшиж, идэвх чармайлт гарган 3,0 ба түүнээс дээш голч дүнтэй суралцах;
- 5.2.3 Ажилтан суралцаж байх хугацаандаа компанид тулгамдаад буй асуудал, сэдвийг хөндсөн, үр бүтээлтэй байдлаар курсын ажил, бие даалт, дипломын ажлыг хийж Техникийн бодлого төлөвлөлт, шуурхай ажиллагааны албанд танилцуулах;
- 5.2.4 Хичээлийн жилийн улирал бүрийн эцэст өөрийн дүнгийн хуулбар, суралцсан хугацааны тайланг бичиж Захирлын зөвлөлийн хуралд тайлагнах;
- 5.2.5 Ажилтан хүндэтгэн үзэх шалтгаанаар суралцах боломжгүй болсон, суралцах хугацааг түр зогсоосон буюу сургуулиас чөлөө авсан тохиолдолд энэ тухай Компанид мэдэгдэх ба үүнтэй холбоотой асуудлыг шийдвэрлүүлэх;
- 5.2.6 Өөрийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан гэрээний 5.2.2-д зааснаас доош голч дүнтэй суралцсан, сахилга хариуцлагын ноцтой зөрчил гаргасан, сургуулиас хөөгдсөн, "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн 39 дүгээр зүйл болон 40 дүгээр зүйлд заасны дагуу Ажилтантай байгуулсан "Хөдөлмөрийн гэрээ"-г цуцалсан тохиолдолд Компанид учирсан хохирлыг бүрэн хариуцах;
- 5.2.7 Гэрээнд заасан сургалтын хугацаа дуусч, амжилттай төгссөн өдрөөс эхлэн Компанид 5-аас доошгүй жилийн хугацаанд компанийн захиргаанаас томилсон шаардлагатай ажлын байранд тогтвор суурьшилтай ажиллах ба суралцах хугацаанд олж мэдсэн, эзэмшсэн мэдлэг, шинэ санал, санаачилгыг Компанид хэрэгжүүлэн, үр бүтээлтэй ажиллах;

Зургаа. Талуудын хариуцлага

- 6.1 Компани нь Ажилтны сургалтын төлбөрийг тогтоосон хугацаанд сургуулийн дансанд шилжүүлээгүйгээс шалтгаалан Ажилтны суралцах үйл ажиллагаанд саад учирсан тохиолдолд үүнтэй холбогдон үүсэх хариуцлагыг Компани бүрэн хариуцна.

- 6.2 Ажилтны буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан Компани гэрээний 5.2-д заасан үүргээ хэрэгжүүлээгүй бол энэхүү гэрээг дангаар цуцалсан тохиолдолд Компанид учирсан хохирлыг Ажилтан бүрэн хариуцна.
- 6.3 Ажилтан нь гэрээний 5.2.7-д заасан үүргийг эс биелүүлсэн тохиолдолд Компани өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр Ажилтнаас шаардах эрхтэй. Энэхүү заалт нь Ажилтан тогтоосон хугацаанд Компанид ажиллахдаа хөдөлмөрийн үр бүтээмжгүй, идэвх санаачилгагүй ажилласан зэрэг бүхий л тохиолдолд нэгэн адил үйлчилнэ.
- 6.4 Ажилтан Компаниас сургалтын төлбөр гаргуулах зорилгоор худал мэдээлэл өгсөн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн зэрэг гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүй хийсэн нь тогтоогдвол энэхүү гэрээг цуцалж, үүнтэй холбогдон үүсэх асуудлыг холбогдох хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлнэ.


Долоо. Нууцлалын баталгаа

- 7.1 Энэхүү гэрээ нь талуудын нууцад хамаарах бөгөөд талууд харилцан тохиролцож, бичгээр үйлдэн гарын үсгээр баталгаажуулсан, зөвшөөрөлгүй бусдад шилжүүлэх, задруулах, нийтийн хүртээл болгохыг хориглоно.
- 7.2 Талууд гэрээний 7.1-д заасныг зөрчиж гэрээг бусдад шилжүүлсэн, задруулсан, нийтийн хүртээл болгосон тохиолдолд үүнээс шалтгаалан үүссэн хохирлыг буруутай тал нь нөгөө талдаа нөхөн төлнө.

Найм. Бусад зүйл

- 8.1 Талууд энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд санал гаргасан тал нь нөгөө талдаа хуанлийн 14 хоногийн өмнө бичгээр мэдэгдсэний үндсэн дээр талууд харилцан тохиролцож нэмэлт, өөрчлөлт оруулна.
- 8.2 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэн талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээний хувь тус бүр хуулийн адил хүчинтэй байна.
- 8.3 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбогдон үүссэн аливаа маргаан, санал зөрөлдөөнийг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх ба шийдвэрлэх боломжгүй гэж үзвэл харьяалагдах шүүхээр асуудлыг шийдвэрлүүлнэ.


Гэрээ байгуулсан:


Ажилтан:
Турбин-хими цехийн ээлжийн
дарга  Ц.Энхсайхан


Гэрийн хаяг: Улаанбаатар хот,
Сонгинохайрхан дүүрэг, 4 дүгээр
хороо, Их наран, 9-р гудамж, 3 тоот

РД: ЧЕ87031314
Утас:

Компанийг төлөөлж:
Тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий
инженер  Б.Мягмаржав

Захиргаа удирдлагын хэлтсийн
дарга  Г.Мөнгөнцэцэг

Санхүү бүртгэл, эдийн засгийн
хэлтсийн дарга бөгөөд ерөнхий
нягтлан бодогч  О.Энхбаяр

Сургалтын
мэргэжилтэн  Д.Эрдэнэбат

Хуулийн
мэргэжилтэн  П.Наранзул

21/434 тоот гэрээний хавсралт

ТӨЛБӨР ТӨЛӨХ ХУВААРЬ

№	ТӨЛБӨР ТӨЛӨХ ХУГАЦАА	ТӨЛСӨН ХУГАЦАА	ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ /ТӨГРӨГ/	КРЕДИТЫН ХЭМЖЭЭ	ТАЙЛБАР /Гарын үсэг/
1	2019.10 сар	2019.10.17	1,634,400	18	Төлсөн
2	2020.02 сар	2020.02.06	1,997,600	22	Төлсөн
3	2020.09 сар	2020.09.09	1,997,600	22	Төлсөн
4	2021.02 сар		1,543,600	17	
5	2021.09 сар				
6	2022.02 сар				